

Эрх баригчдад гаргаж буй энэ уриалга хүний эрхийн зөрчилд өртсөн хохирогчдод туслах юм. Та үзэл санааны хоригдлыг суллаж, эрүү шүүлтийг зогсоход тусалж чадна. Мөн хүчээр сураггүй алга болгогсдод хариуцлага тооцож, ялын гүйцэтгэлээс хүмүүсийг аварч чадна.

2008 оны 11 дүгээр сар

Шри Ланка



Жаяпракша Ситалапал Тисанаягамийг Терроризмээс сэргийлэх хуулийн дагуу нэрийдлээр ажлаа хийж байхад нь баривчилж 7 сар гаруй хугацаанд хорьжээ.

Эмнести Интернэшнл түүнийг үзэл санааны хоригдол хэмээн үзэж байна. Түүний хувьд нүдний хараа муудах, өвдөх зэрэг бэрхшээл тулгараад байгаа бөгөөд

Терроризмийн тухай хуулиар сэтгүүлчийн дуу хоолойг хорьжээ

эмнэлэгийн үйлчилгээ авч чадахгүй байгаа юм. 3 дугаар сарын 7-нд Коломби дахь Терроризмийн хэргийг шалгах газар эхнэр болон хамт ажилладаг хүмүүсийг нь баривчилсан хэргийг асууж лавлахаар очиход нь түүнийг баривчлан, хорьсон байна. 3 дугаар сарын 27-нд Шүүх «Терроризмийн хэргийг шалгах газар»-т хоригдогчийг 7 хоногоос илүү хорих ёсгүй гэдгийг үндэслэн шийдвэр гаргасан боловч «Тамил Еламыг Чөлөөлөх Барсууд Үлэглэл»-ийн нэрийн өмнөөс ажиллаж байсан хэмээгдэж 90 хоног хүртэл хугацаагаар хоригдох болсон байна.

6 дугаар сарын 7 гэхэд тэрээр дахин 3 сар нэмж хоригдохоор яллагдсан байна.

8 дугаар сарын 25-нд түүнийг Дээд шүүхээс Терроризмээс сэргийлэх тухай хуулийн 1979-ийн 49 дүгээр зүйлээр ялласан байна. Энэ ял нь «Зүүн хойг» сар тутмын сэтгүүлд бичсэн Шри Ланка дахь иргэний болон улс төрийн бослого тэдэнд хэрхэн нөлөөлсөн талаархи өгүүлэлүүдтэй нь холбоотой байв.

Мөн цөөнхийг өдөөн турхирч, сэтгүүлээр дамжуулан террористуудад туслах зорилгоор мөнгө цуглуулсан гэж буруутгасан байна. Тус хууль нь олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээнд үл нийцэх бөгөөд улс төрийн сөрөг хүчнийхний эсрэг хэрэглэгдсээр байна. Энэ хэрэг бол Шри Ланка дахь хүний эрхийн төлөө тэмцэгчдийг дуугүй болгохоор шүүх

хуралдаангүй, оноосон ялгүйгээр хорьдог засгийн газрын нийтлэг аргуудыг нэг юм.

Сэтгүүлчийн ажлаа хийснийхээ төлөө баривчлагдсан Ж.С.Тисанаягамыг үзэл санааны хоригдол гэж үзэж буйгаа илэрхийлэн даруй ямарваа нөхцөлгүйгээр суллахыг шаардан захидал бичнэ үү.
His Excellency the President Mahinda Rajapaksa
Presidential Secretariat
Colombo 1
Sri Lanka
Fax +94112446657
Salutation. Your Excellency

Манай бүх уншигчдад

12 дугаар сард та бүхэн шинэ дизайн бүхий шинэчлэгдсэн Wire сониноо хүлээн авах болно. Бид шинэ Wire сонингоороо та бүхэнтэй дахин уулзахаар тэсч ядан хүлээж байна. Хэрэв сонинг маань хүлээн авахыг хүсвэл ppmsteam@amnesty.org хаягаар хандаарай. **Аз жаргал хүсье.**
Wire бар

Израйль

16 настай Сальва болон түүний үеэл Сара Слур нар 6 дугаар сараас хойш Израйлийн төв шоронд хоригдож байна. Тэд энэ сард 17 нас хүрч байгаа бөгөөд тэднийг 2008 оны 6 дугаар сарын 4-нд Израйлийн цэргүүд Палестины Баруун эрэг дахь Бетлехэм дэх гэрээс нь баривчилжээ. Израйлийн цэргийн төв шоронд 4 сарын турш шүүх хуралгүйгээр хорьсон байна.

10 дугаар сарын 5-нд хоригдох хугацаа нь дууссан боловч 2009 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийг хүртэл хугацааг 3 сараар сунгасан

Шүүх хуралд оруулалгүйгээр өсвөр насны охидыг хорьжээ

байна. Израйлийн армийнхан охидыг аюулгүй байдалд халтай үйл ажиллагаанд оролцсон гэж байгаа бөгөөд энд нь ямар нэг нотолгоо байхгүй байна.

Палестинд хүүхдийн эрх хуулиар хамгаалагдаагүй, мөн Израйльд хүүхдийг хамгаалах хууль байгаа боловч Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцид нийцэхгүй байгаа юм.

Израйль улс уг Конвенцид нэгдэн орсон боловч хуулиараа Палестин болон Израйль хүүхдүүдийг алагчилж байна хэмээн НҮБ-ын

Хүүхдийн Эрхийн Хороо үзэж байна.

Энэ нь Палестины хоригдлууд Израйльд бус харин Палестины эзлэгдсэн бүс нутагт хоригдох ёстой гэсэн Женевийн Дөрөвдүгээр Конвенцийг мөн зөрчиж байгаа юм.

Өдгөө Израйлийн шоронгуудад 275 палестин хүүхэд хоригдож байгаа ба тэдний 13 нь шүүх ажиллагаагүйгээр хоригдож байна.


Сальва, Сара Слур нар нь гэмт хэрэгт буруутгагдаж яллагдаагүй л бол нэн даруй суллах, олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд бүрэн нийцсэн шударга шүүх хурлаар

хэргийг нь шийдэхийг шаардан доорхи хаягаар захидал бичнэ үү.

Shimon Peres
President of the State of Israel
The Office of the President
3 hanassi Street, Jerusalem 92188, Israel
Fax +97225611033
+97225664838
+97235627265
Email: info@peres-center.org
public@president.gov.il,
president@president.gov.il,
s_peres@netvision.net.i

Дараах мэдээлүүдийг доорхи хаягаар аваарай.

www.amnesty.org
www.amnesty.mn



Мозамбик



Абранчес Афонсо Фенисло цагдаагийн дайралтад өртсөний дараа буюу 2007 оны 8 дугаар сарын 15-нд эмнэлэгт нас баржээ. Энэ явдлын өмнөх өдөр түүний гэрт 5 цагдаа иржээ.

Түүнийг цагдаа нар машинд хүчээр хийн, хотоос 140 км-ийн

Цагдаа нарт үхтлээ зодуулжээ

зайд орших эзэнгүй газар аваачин ухаан алдтал нь зодсон байна. Дараа нь түүний хүзүү рүү буудаад орхин явжээ. Гэвч тэрээр амьд гарч, мөлхсөөр замын ойролцоо хүрч чадсан аж. Ойр орчмын хүмүүс түүнийг олж эмнэлэгт хүргэжээ. Гэр бүлийнхний нь мэдэгдэж буйгаар цагдаагийнхан тэр шөнө Мапуто дахь эмнэлэгт ирж гэрчийн мэдүүлэг авсан байна. Цагдаагийн хэд хэдэн албан тушаалтнуудын байцаалтыг гэр бүлийнхэн нь утсаараа бичиж

авчээ.

Абранчес Фенислог цагдаагийнхан сүүлийн 10 жилийн турш дарамталж байсан аж.

1999 оны 12 дугаар сард түүний гэрийнх нь эд хөрөнгийг хураасан авч юуг ч буцаан өгөөгүй байна. Хорих хугацаандаа олон удаа зодож байжээ. 2007 оны 3 дугаар сарын 13-нд шүүгчийн нэн даруй суллах шийдвэрийг үл харгалзан 5 хоног илүү хорьсон байна. Хурал хойшлогдож 2007 оны 8 дугаар сард энэ хэргийг

дахин сөхсөн авч гэр бүлийнхэнд нь мэдэгдээгүй байна. Харин 7 хоногийн дараа түүнийг хөнөөсөн юм.

Цагдаагийнхан Абранчес Афонсо Фенислог хөнөөсөн хэргийг шалгаж, буруутай этгээдэд шударгаар хариуцлага тооцохыг шаардаж дараах хаягаар захидал бичнэ үү.

Exmo Sr.Dr. Augusto Paulino
Procurador Geral da Republica
Maputo, Mozambique
FaxFax +25821492758/80
Salutation/ Excelencia
/your Excellency /



Туркменистан



Туркменистаны гадаад хэргийн сайд асан Борис Шехмурадовт 2002 оны 12 дугаар сарын 29-нд болсон хаалттай шүүх хурлаар 25 жил хорих ял оноожээ. Энэ нь Иргэдийн зөвлөлөөс түүний ялыг бүх насаар нь хорих ял болгон өөрчилсөнтэй холбоотой юм. Түүний ах Константин

Шударга бус шүүх хурлын дараа алга болжээ

Шехмурадов мөн 17 жил хоригдох ял авчээ. Тэднийг 2002 онд ерөнхийлөгч Сапармурад Нъязов руу дайрсан зэвсэгт халдлагад холбоотой хэмээн бусад 57 хүний хамт буруутган ялласан аж.

Борис Шехмурадовын шүүх ажиллагааны дараахан түүний эхнэр Татьяна Эмнести Интернэшнлийнхэнд «гэрч боломж өргөмөлөгчдөд үгээ хэлэх боломж олгосон эсэхийг мэдэх арга алга байна» гэж хэлсэн юм.

Тэрээр нөхрөө баривчлагдсанаас хойш засгийн газарт маш олон удаа хандсан


боловч ямар ч хариу сонсоогүй байна.

2007 онд АНУ-ын Колумбын их сургуульд хийсэн ярилцлагын үеэр ерөнхийлөгч Гурбангул Бердимухмадовоос тэднийг амьд байгаа эсэхийг асуухад «Би энэ хэрэгт холбоогүй. Гэхдээ би тэднийг амьд байгаа гэдгийг хэлж чадна» гэжээ. Энэ хариулт нь Татьяна, Аяна нарын цорын ганц найдвар болоод байна.

Ерөнхийлөгч Гурбангул Бердимухмадовыг сураггүй алга болоод байгаа Борис, Константин Шехмурадов нар болон бусад

хүмүүсийн хаана байгаа талаар даруй мэдээлэл хийхийг уриалан захидал бичнэ үү. Мөн 2002 оны халдлагад буруутгагдан шүүх хурлаар ялагдсан хүмүүсийн хэргийг шалган, хүчээр сураггүй алга болгогсдод хариуцлага тооцохыг шаардан доорхи хаягаар захидал бичнэ үү.

President Berdymukhamedov
744000.g.Ashgabat
Apparat Presidenta
Presidynty Turkmenistana
Turkmenistan
Fax +99312355112





ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТҮНХАГЛАЛ: ТОО, БАРИМТУУД

Нэгдүгээр зүйл

1948 оны амлалт:

Хүн бүр төрж мэндлэхдээ эрх чөлөөтэй, адилхан нэр төртэй, ижил эрхтэй

2008 оны бодит байдал:

2007 оны эхний хагас жилийн байдлаар Египет улсад 250 эмэгтэй гэр бүлийн хүчирхийлэлд өртөн эр нөхрийнхөө гарт амиа алдсан бөгөөд дунджаар цаг тутамд 2 эмэгтэй бэлгийн хүчирхийлэлд өртөж байна.

Гуравдугаар зүйл

1948 оны амлалт:

Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй.

2008 оны бодит байдал:

Хэдийгээр 104 улс цаазаар авах ялыг гүйцэтгэхэд түдгэлзүүлэхийг дэмжиж санал өгсөн ч 2007 онд 24 оронд нийтдээ 1,252 хүн цаазлагдаад байна.

Тавдугаар зүйл

1948 оны амлалт:

Хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, хүний ёсноос гадуур эсхүл нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэхийг хориглоно.

2008 оны бодит байдал:

2007 онд эрүүдэн шүүж, хүнлэг бусаар хүний нэрг төрийг доромжлон харьцсан 81 улс байна.

Долдугаар зүйл

1948 оны амлалт:

Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаваргүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй.

2008 оны бодит байдал:

Хуулиараа 23 улс эмэгтэйчүүдийг, дор хаяж 15 улс цагаачдыг, 14 улс үндэсний

цөөнхийг ялгаварладгийг Эмнести Интернэшнлийн тайлан онцолсон байна.

Есдүгээр зүйл

1948 оны амлалт:

Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй.

2008 оны бодит байдал:

2007 сүүл гэхэд, Афганистаны Баграм дахь Америкийн цэргийн баазад 600 гаруй хүн шүүх хурлаар хэргээ шийдүүлэлгүйгээр, ямар нэг ял шийтгэлгүйгээр хоригдож байгаа бөгөөд Ирак дахь Олон үндэстний хүчин 25,000 хүнийг хориод байна.

Аравдугаар зүйл

1948 оны амлалт:

Хүн бүр эрүүгийн ял тулгавал тэр нь хир зэрэг үндэслэлтэй болохыг тогтоолгохын тулд тухайн хэргийг бүрэн тэгш эрхийн үндсэн дээр ил тод байдлаар, шударга, бусдын нөлөөнд автагдаагүй, гагцхүү хуулинд захирагдах шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй.

2008 оны бодит байдал:

54 улсад шударга бус шүүх ажиллагаа явагдаж нь 2008 оны Эмнести Интернэшнлийн тайланд бүртгэгджээ.

Арваннэгдүгээр зүйл

1948 оны амлалт:

Гэмт хэрэгт яллагдаж буй хүн бүр хуулийн дагуу гэм буруутай нь тогтоогдох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй.

2008 оны бодит байдал:

2002 оны 1 дүгээр сард Гуантанамо Байд урьдчилан хорих төв нээгдсэнээс хойш 800-гаад хүн хоригдоод байгаа бөгөөд 2008 оны байдлаар тэдний 270 нь хуулийн дагуу

хэргээ шийдүүлэлгүйгээр хоригдсоор байна.

Арвангуравдугаар зүйл

1948 оны амлалт:

Хэн ч бай улс орны дотор чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгон авах эрхтэй.

2008 оны бодит байдал:

2007 онд Баруун эрэг дэх хот тосгод дахь Палестинчуудын шилжих хөдөлгөөнөөс сэргийлэх, хязгаарлах зорилгоор Израйлийн арми хамгаалалтын хана босгож, 550 гаруй шалган нэвтрүүлэх цэг байгуулаад байна.

Арваннаймдугаар зүйл

1948 оны амлалт:

Хүн бүр чөлөөтэй сэтгэх, шүтэж бишрэх, сүсэглэх эрхтэй.

2008 оны бодит байдал:

45 улсад үзэл санааны хоригдол байгааг Эмнести Интернэшнл бүртгээд байна.

Арванесдүгээр зүйл

1948 оны амлалт:

Хүн бүр өөрийн үзэл бодолтой байж түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, үүнд үзэл бодлоо ямар ч хориг цээргүй баримтлах, аливаа үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл харгалзан боломжтой арга замаар эрж сурвалжлах, олж ашиглах, түгээн дэлгэрүүлэх эрх багтана.

2008 оны бодит байдал:

77 улс үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө, хэвлэн нийтлэх эрхийг хязгаарладаг нь 2008 оны Эмнести Интернэшнлийн тайланд оржээ.

Хорьдугаар зүйл

1948 оны амлалт:

Хүн бүр өөрийн үзэл бодолтой

байж түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй

2008 оны бодит байдал:

2007 онд Бирмд болсон жагсаалын үеэр хэдэн мянган хүн баривчлагдсан бөгөөд 700 гаруй нь одоо болтол хоригдсоор байна.

Хорингуравдугаар зүйл

1948 оны амлалт:

Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, таатай нөхцлөөр хангуулах, ажилгүйдлээс сэргийлэн хамгаалуулах эрхтэй.

2008 оны бодит байдал:

2007 онд Колумби улсад дор хаяж 39 Үйлдвэрчний эвлэлийн гишүүн алагдсан бөгөөд он гараад 22 хүн эхний 4 сард алагдаад байна.

Хоринтавдугаар зүйл

1948 оны амлалт:

Хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй үйлчилгээ авах эрхтэй.

2008 оны бодит байдал:

2007 онд Малави улсын хүн амын 14% нь ХДХВ, ДОХ-ын вирус тээж байгаа бөгөөд ердөө 3% нь л эмнэлгийн тусламж, эмээр хангагдаж байна. ДОХ-той холбоотой нас баралтын улмаас 1 сая гаруй хүүхэд өнчрөөд байна. (Дээрх мэдээг Эмнести Интернэшнлийн 2008 оны тайлангаас авав)

Дэлгэрэнгүй мэдээллийг 324705 утсаар эсхүл Лондон дахь олон улсын төвийн +44 20 7413 5566 тоот утсаар, мөн aimncc@magicnet.mn эсхүл press@amnesty.org хаягаар хандана уу.

www.amnesty.org
www.amnesty.mn